“ФИЛОСОФИ БА ШИНЖЛЭХ УХААНЫ ТАНИН МЭДЭХҮЙ: ОНОЛ-АРГА ЗҮЙН АСУУДЛУУД” СЭДЭВТ ЭШХ-ЫН ХЭВЛЭЛИЙН МЭДЭЭ

Философийн өдрийг тохиолдуулан ШУА-ийн Философийн хүрээлэн, ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комисс хамтран “ФИЛОСОФИ БА ШИНЖЛЭХ УХААНЫ ТАНИН МЭДЭХҮЙ: ОНОЛ-АРГА ЗҮЙН АСУУДЛУУД” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг 2022 оны 11 дүгээр сарын 17-ны Пүрэв гарагт ШУА-ийн Хүрээлэнгүүдийн нэгдсэн II байрны Хурлын танхимд 9:00-15:30 цагт зохион байгуулна.

Философи нь бусад хүмүүнлэгийн ухаан, нийгмийн ухаан, шинжлэх ухаантай харилцан холбогдож, дэлхий даяарх туршлага, соёлын олон ургальч үзлийг тусгаж, нийгмийн өөрчлөлтийн асуудалд шийдэл гарцыг олоход хувь нэмрээ оруулж байдаг мэдлэгийн салбар. Иймд НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага ЮНЕСКО-оос жилийн бүрийн 11 дүгээр сарын 3 дахь долоо хоногийн Пүрэв гарагт “Дэлхийн философийн өдөр” хэмээн зарласан бөгөөд ШУА-ийн Философийн хүрээлэн, ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комисс хамтран 10 дахь жилдээ тэмдэглэж байна.

Энэ удаагийн хуралд ШУА-ийн Философийн хүрээлэн, МУИС, ШУТИС, ШУА-ийн ФТХ, Удирдлагын академи, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, ШУТИС-ийн харьяа “Эрдэнэт цогцолбор” дээд сургууль, Олон Улс судлалын Дээд сургууль, Дотоод хэргийн Их сургуулийн багш, судлаачид илтгэл хэлэлцүүлж оролцоно. Хурлын илтгэгчид 1.Философи мэдлэгийн арга зүйн үнэ цэн, философийн судалгааны арга зүйн чиг хандлага, 2.Байгаль, нийгмийн шинжлэх ухааны философи арга зүйн асуудал, 3.Шинжлэх ухааны танин мэдэхүй, академик эрх чөлөө, ёс зүйн асуудлаар нийт 20 илтгэлийг хэлэлцэх юм.

Хуралд тавигдах илтгэлүүд нь философи ба шинжлэх ухааны танин мэдэхүйн хүрээний асуудлуудыг хамарч буй бөгөөд эмхэтгэл болгон хэвлүүлж тус хурлын үеэр нийтийн хүртээл болно. Тус илтгэлүүд нь эцсийн дүндээ философийн үүднээс шинжлэх ухаан, танин мэдэхүй, арга зүйн асуудлыг шинжилсэн, аливаа үзэл баримтлалыг үндэсний онцлог, сэтгэлгээний өв уламжлалдаа нийцүүлэн бүтээлчээр хэрэглэх боломж, арга замыг эрэлхийлсэн болохыг онцлон тэмдэглэе.

Зохион байгуулагч: ШУА-ийн Философийн хүрээлэн,
Философийн салбар

Дэмжигч байгууллага: ЮНЕСКО-ийн Бээжин дэх төлөөлөгчийн газар
ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комисс

United Nations Educational, Scientific and Cultural Organization · Mongolian National Commission for UNESCO

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН

United Nations Educational, Scientific and Cultural Organization · Beijing Office
Office of the Representative to Democratic People's Republic of Korea, Japan, Mongolia, People's Republic of China, and Republic of Korea

ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН 50 1972-2022

ОГНОО 2022.11.17

ЦАГ 09:00-15:30

УТАС 11-330-847, 99710703

ШУА-ИЙН ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН
ХҮРЭЭЛЭНГҮҮДИЙН НЭГДСЭН II БАЙР, 4 ДАВХАР